

3-р хичээл: Аврал, өргөмжлөлийн ажил

Та энэхүү хичээлийг бүхэлд нь эсвэл богино хэсэгт хуваан зааж болно. Хичээлийг заахдаа тухайн орон нутгийнхаа нөхцөл байдал, чуулга эсвэл ангийн ерөнхийлөгчийн зөвлөлийнхөө хэрэгцээ, нас, ойлголтод тулгуурлаарай.

ЧУУЛГА, АНГИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛ

Ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүдийг *Ерөнхий гарын авлага: Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд үйлчлэх нь, 1.2* (ChurchofJesusChrist.org) гарын авлагыг хамтдаа уншиж, Их Эзэний тэднээр гүйцэлдүүлэхийг хүсдэг ажлыг хайж олоход урь. Яагаад энэ ажил чухал вэ? Бид эдгээр зорилгыг гүйцэлдүүлэхийн тулд юу хийж байна вэ? Бид эдгээр зорилгыг илүү сайн гүйцэлдүүлэхийн тулд ямар ямар зорилгыг тохируулан өөрчилж мөн тавьж болох вэ?

ЧУУЛГА, АНГИЙН ГИШҮҮДИЙГ ЭНЭХҮҮ АЖИЛД ОРОЛЦУУЛАХ

Ерөнхийлөгчийн зөвлөлийн хувьд хэлэлцэж төлөвлөсөн зүйлсээ эргэн харахыг ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүдээс хүс. Та ерөнхийлөгчийн зөвлөлийн хурал цуглааны хөтөлбөр, үйлчлэлийн төлөвлөгөө болон үйл ажиллагаануудыг эргэн харахыг тэдэнд санал болгож болно. Тэгээд дараах асуултуудыг тавь.

- Бид аврал, өргөмжлөлийн ажилд хэрхэн аль хэдийн төвлөрчихсөн байгаа вэ?
- Бид ямар зүйл дээр сайжирч болох вэ?

Чуулга, ангийн гишүүдэд аврал, өргөмжлөлийн ажилд илүү бүрэн дүүрэн оролцоход нь хэрхэн тусалж болох талаар хэлэлцэхэд ерөнхийлөгчийн зөвлөлийг урь. Ерөнхийлөгчийн зөвлөл эсвэл чуулга юм уу анги нь дараах асуултуудыг хэлэлцэж болно. Үүнд:

- Бид Есүс Христийн сайн мэдээний дагуу илүү сайхан амьдрахад нь нэг нэгэндээ хэрхэн тусалж чадах вэ?
- Тусламж хэрэгтэй байгаа хүмүүст анхаарал тавихын тулд бид юу хийж чадах вэ?
- Хүмүүсийг сүмд ирэхэд нь бид хэрхэн уриалгахан бөгөөд найрсгаар угтаж болох вэ?
- Гэр бүлийн түүхийн болон ариун сүмийн ажлын оролцоог бид хэрхэн дэмжиж болох вэ?

(Тавьж болох асуултуудыг [Ирээд, Намайг дага-Аароны санваарын чуулга болон Залуу эмэгтэйчүүдийн ангиудад зориулав](#) гарын авлагын хичээл болгонд байгаа “Хамтдаа зөвлөлд” хэсгээс олж үзнэ үү.)

НЭМЭЛТ ЭХ СУРВАЛЖ

- *Ерөнхий гарын авлага, 1-р бүлэг*
- “Youth Responsibility in the Work of Salvation” видео бичлэг
- Кэрл Ф.Макконки, “Бид энд зөв шударга үйл хэрэгт үйлчлэхээр ирсэн,” *Ensign* эсвэл 2015 оны 10-р сарын *Ерөнхий чуулган*, 134
- [Ефес 4:11–13](#); [Моронай 10:32](#); [Моисе 1:39](#)